

Ч. ДАЛАЙ
Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Юан гүрний үед нэр цууд гарсан төр улс, бичиг соёлын болон цэргийн өдий төдий зүтгэлтэн монгол хүн байжээ. Гагцхүү эдүгээ хүртэл манай түүхчид тэдгээр хүмүүсийн үйл явдлыг нэг их нарийвчлан судлаагүй байна. Тэдний түүх намтрыг судлах явдал Монголын дундат зууны үеийн түүхийн судлалд нэн чухал нэмэр хандив болох юм. Иймээс хойшид үргэлжлэх энэхүү цуврал судалгааныхаа эхний өгүүллийг Баян, Тогтох хоёрын үйл амьдралаар эхэлье.

Баян, Тогтох хоёрын үйл амьдралыг судлах явцанд тухайн үеийн Монгол хаад, язгууртны тансаг бурангуй амьдралын ялзрал доройтол, хааны ордны доторх ихэс дээдсийн хоорондын түмэн зөрчил, Юан гүрний сүр хүчин доройтож Хятадын ард түмнээс харь Монголын ноёрхлыг эсэргүүцсэн тэмцэл хүчтэй болж байсныг судлан мэдэж болно. Мөн түүнчлэн монгол хаад, ноёдын хоорондын зөрчлийг ашиглан хооронд нь мөргөлдүүлэх ажлыг нарийн аргаар хийж байсан хятад бичгийн түшмэдийн уламжлалт аргыг олж мэдэх юм.

Юан гүрний хэд хэдэн Баян нэртэй төр, цэрэг бичгийн түшмэл байсан. Бидний өгүүлэн буй Баян бол Тогоонтөмөр хааны хаанчлалын эхэн үед гүрний төр цэргийн бүх эрхийг гартаа барьж байсан бөгөөд Монголын Мэргэд аймгийн хүн.¹ Сурвалж бичгийн мэдээнээс үзвэл Тогоонтөмөрийн хаанчлалын эхэн үед Баянгийн бүх хэргэм зэрэг, мяндаг тушаал бүгд 246 байсан ажээ.² Тэр байтугай гүрний хэмжээгээр нэг хэсэгтээ Баян гэдэг нэрийг л олж сонссоноос биш Тогоонтөмөр хааны нэрийг бараг мэддэггүй байсан гэж ярилцдаг байжээ.³ Ер нь нэг хэсэгтээ Баян хааны ордны дотор хамгийн дээд эрхийг олж бүх асуудлыг хааны нэрээр гагцаар шахам шийдэж байсан нь үнэн ажээ.

«Юань ши» зэрэг хятад сурвалж бичигт: Баяныг хаан төрийн бүх эрхийг булаан авсан хэрцгий харгис, шалиг завхай зантай, шалгалтын журмыг устгасан, хятад түшмэл нарыг төрийн хэргээс шахан зайлуулдаг, Монголынхоо эртний бүдүүлэг бурангуй ёсыг сэргээх гэсэн гэх мэтээр ихэд муучлан бичсэн нь үзэгдэнэ. Тэр бүхнийг нарийвчлан судалж үзвэл бас ч тийм учир шалтгаангүй зүйл биш байсан бололтой. Хэдийгээр Баянд ноёрхогч ангийн бүх талын шинж онцгой их байгаа хэдий боловч Монгол гүрнийхээ төлөө чин үнэнч зүтгэж, хятад түшмэдийн заль мэхийг сайтар ойлгож байжээ.

Баян бол Өгэдэй хааны үеийн Монгол улсын төрийн ёс дэглэмийг сэргээж Өгэдэй дээдсийн баримталж агсан монгол аргаар гүрнийг за-

¹ «Чжунгожэньминь да цыдянь» — («Хятад хүний нэрийн их толь») 1940, Шанхай. 284-р талд бичсэн нь: Баян бол Монголын мэргэд аймгийн хүн. Багаас ухаан сэргэлэн, Монгол нутагтаа суух дуртай, дайн тулалдаанд олон удаа орж гавьяа байгуулж явсан. Хааны оронд эрх тушаалаа хэт ашигласан учир хаан дургүйцэж Хэнань-д явуулж байгаад тушаалаас нь зайлуулсан» гэжээ.

² «Юаньши» дзи бэйфан минцзу ши яньцзю чжи кан» (Юаньши ба умарт зүгийн үндэстнүүдийн түүхийн судалгааны цуврал) 1983, Наньжин, No 7, 10—21-р тал.

³ «Юаньши», 138-р бүлэг

хирна. Харин Хубилай хаан бол хятад түшмэдийн арга ухаанд хэт автагдаж, Монгол улсын хаан ширээ залгамжлах ёсыг сүрхий эвдсэн гэж үздэг байжээ. Чухам ингэж төрийн эрхнээс хятад түшмэл нарыг хавчин шахаж гаргах ажлыг хүчлэн хийж байжээ. Нөгөө талаар Баян үзэхдээ шалгалт өгч тушаалд дэвших замаар төрийн хэрэгт оролцох хятад түшмэд олон болж зарим монгол түшмэл нар хятад багш нарын арга ухаанд автаж байна. Хятад багш нар бичиг ном зааж шалгалт авах нэрийдлээр төрийн эсрэг арга ухааныг шавь нартаа зааж сургадаг. Тэр ч байтугай монгол хүн хятад бичиг сурахаар санаа нь хувирдаг. Иймээс шалгалтын журмыг зогсоох нь зүйтэй гэж үзжээ. Мөн монгол хүн бол яг морь унасан, мах идсэн монгол байх ёстой. Гүрний төрийг зэвсгийн хүчээр барина. Хаан ширээг Монголын их хуралдайн журмаар залгамжлах ёстой гэж тэрээр үзэж байжээ. Чухам ингэж Баян бол монгол ёсыг хэт сахисан, үндсэрхэг үзэлтэй хүн байсан учир тухайн үедээ ордны доторхи олонхийн дургүйцлийг хүргэжээ. Баяныг тийм их өндөр эрх тушаалаас нь зайлуулж чадах хүн гагцхүү Тогтох байжээ. Иймээс Тогтохын номын хятад багш У Чжифан энэ талаар идэвхтэй ажиллажээ.

Тогтох бол мэргэд аймгийн Мухлай жанжны удмын хүн байжээ.⁴ Тэрээр хар багаасаа амьдралын хүнд бэрхийг туулсан угаас сэргэлэн ухаантай нум сум харвах гоц авьяастай ажээ⁵. Иймээс түүнийг Баян түшмэл гэртээ авчирч өөрийн өргөмөл хүн болгон өсгөжээ. Тогтохыг өвөг Мухлайн адил авьяаслаг цэргийн жанжин болно гэж Баян бат итгэж түүнд цэргийн эрдэм, монгол ёсоор төр барих арга болон хятад түшмэдийн далд санааг хүртэл ярьж өгдөг байжээ.

Тогтохын номын багш нь У Чжифан гэдэг нэрд гарсан күнзын сургаалтан бичгийн түшмэл байжээ. Тогтох хятад багшийн заасан бүхнийг сурч номын авьяас билиг нь тодорчээ. Тогтох «Өдөржин сөхрөн сууж ном уншдаг»⁶ гэж сурвалжид тэмдэглэжээ. Тухайн үеийн монгол сурвалжтан дотроос хамгийн олон боть ном уншиж эрдэм номд төгс боловсорсон хүн бол Тогтох байжээ. Тэр ч байтугай хятад хэлийг бараг багшаасаа илүү сайн сурсан гэдэг. Тэр 15 наснаасаа эхлэн цэргийн эрдэмд биш, номын хүн болъё гэж нэгэнт шийджээ. Тэр үеэс Баян Тогтох хоёрын хооронд зөрчил үүсч эхэлжээ. Энэ байдлыг хятад багш У Чжи фан овжин ашиглаж түүнд хичээл заах бүрийд төрийн эрх булаах нарийн арга ухаан, аливаа зөрчлийг ашиглан хүнийг түлхэн унагах арга, хаан эзэнд санаа бодлоо итгүүлэх уйгагүй зүтгэлийн тухай зааж өгдөг байжээ. Тогтох авга эцэг Баянтай тэмцэх санаа шулуудан уг санаагаа Тогоонтөмөр хаанд яаж итгүүлэн ойлгуулах вэ гэдгийг нарийвчлан тунгаан боджээ. Тогтох нэгэн өдөр эцэг Мазартайд хэлсэн нь: «Өвөг эцгийн бардамнан эзэрхэх нь хэтрэв. Тэнгэр эзэн хүртэл уурлан хилэгнэнэ. ... Хэрвээ түүнийг дийлэх арга ухааныг сийлээд бүтэхгүй бол яах билээ»⁷ Мазартай шийдвэртэй хариу өгсөнгүй. Тогтох номынхоо багш У Чжифанаас асуужээ. У Чжифан: «Их үйлийн төлөө төрөл саднаа ч мөхөөж болно. Их түшмэл болж улс гүрэндээ шудрага хэрэг үйлдэхээс өөр илүү харамсах зүйл юухан байх билээ». Тогтох: «Хэрвээ хийгээд бүтэхгүй бол яахсан билээ»? У Чжифан: «Хийгээд бүтэхгүй бол эзэн тэнгэрийн хэрэг бизээ. Нэг үхвэл эргэж босохгүйд юунд харамсана.

⁴ «Юаньши» 138-р бүлэгт Тогтохын намтар бий. «Юаньши» 1958, Шанхай, 2-р боть, 1589-р тал.

⁵ «Юаньши» 138-р бүлэг. 1590-р тал

⁶ «Юаньши» 138-р бүлэг. 1589-р тал

⁷ Чэнь Банчжань «Юаньши цзи-ши бэньмо» («Юань улсын судрын хэргийн тэмдэглэлийн эх адгийн бичиг») Чунчин, 1979, 185-р тал

Үхлээ ч гэсэн үнэнч шудрага ул мөрөө бүү баллагтун». Тогтох багшийн үгийг сонсоод зогтусангуут миний санаа шулуудлаа гэжээ.⁸ Дээрх яриануудаас дүгнэлт хийж үзвэл тухайн үед хаан төрийн дотоод хэрэгт хятад түшмэл нарын ил, далдуур гүйцэтгэж байсан ажил явууллага хэрхэн нөлөөлж байсан нь тодорхой байна.

Тогтох хэдэн удаа Тогоонтөмөр хаанд бараалхаж Баянгийн эрх тушаалаа хэт буруугаар ашиглаж байгааг нэгд нэггүй ярьжээ. Хаан эхлээд нэг л сайн итгэхгүй байснаа сүүлдээ нилээд ойлгож Баянг түр зуур хөдөө нутагт зугаалахаар явуулж араар нь Тогтохтой уг асуудлыг илэн далангүй ярилцаж байж шийдье гэжээ. Ингээд Баян цөөн тооны цэрэг авч хөдөө яваад буцаж ирэхэд Баянг тушаалаас нь зайлуулсан тухай хааны зарлиг нэгэнт гарсан байжээ. Ингээд хааны ордноос хөөгдөж хөдөө явах замдаа нэгэн өвгөнтэй дайралдаж Баян асуусан нь: «Хүү нь эцгээ хороож байсан хэргийг та амьдралдаа дуулсан уу?» Өвгөн: «Хүү нь эцгээ хороож байгааг дуулаагүй юм байна. Харин түшмэд нь хааныгаа хороож байгааг дуулсан»⁹ гэжээ. Баян үгийг сонсоод таг дуугүй морио унаж цаашаа явсан гэдэг. Яг энэ үеэс Монголын ноёрхол Хятадад унах эхлэл бий болжээ.

Тогоонтөмөр хаан 1343 онд зарлиг буулгаж Ляо, Цзинь, Сун гурван төрийн түүх зохиох нөр их ажлын ерөнхий редактораар 29 настай Тогтохыг тохоон томилжээ. Тогтох уул ажлыг хугацаанд нь хийж дуусгажээ. Ер нь Тогтох бол аливаа ажил хэргийг дан номын ухаанаар бодож сэтгэдэг, гэр орондоо номоос өөр хөрөнгөгүй шахам хүн байжээ. Тогтох улаан алчууртны бодлогыг дарах хэрэгт оролцож цэрэг авч байлдаж явжээ. Тогтохын эхнэр уран сийлбэрчин байсан гэдэг.

Тогтохоос хойш Тогоонтөмөр хааны баруун гарын даамал түшмэлээр Хами, Тайпин, Сослан нар дараалан томилогдож нэг нэгийгээ алжээ. Тэдний дотроос Хамт Сослан нар бол төрийн хэргийг хамгийн их хутган үймүүлсэн хүмүүс юм. 1354 онд Хами баруун гарын даамал түшмэл болмогц Тогтохыг устгах ажлыг сэдэж далд муу санаагаа хэрэгжүүлэх гэж удаа дараа оролдсоор 1355 оны 12-р сард түүнд хортой архи уулгаж алжээ. 42 настай бичгийн их эрдэмтэн Тогтох ийнхүү нас баржээ. Тогтохын дүү Есөнтөмөр, том хүү Самбаону, хоёрдугаар хүү Харжан нар зүг зүгт таран явжээ.

Тогтох нас барахдаа миний номыг битгий хүнд өгөгтүн. Нандигнан хадгалагтан. Хар санаат Хами түшмэл хаан төрийн алтан аягыг хөмрөх нь энэ бизээ. Би ч бас энэ талаар эвгүй хүний арга ухаанд орж алдсан юм гэж хэлсэн гэдэг. Тогтох нас барснаас хойш 13 жил болоод Юан гүрний төр мөхжээ. Тогтохын номын санд Монголын түүхийн маш ховор материал байсан бололтой.

⁸ «Юаньши цзи бэйфан минцзу ши яньцзю чжикан» № 7, 12-р тал.

⁹ Чэнь Банчжань, «Юаньши цзиши бэньмо», 186-р тал.